

Худалдан авах үйл ажиллагааны товч тайлан /2018 оны 03 дугаар улирлын байдлаар

“Монголын Төмөр Зам” ТӨХК-ийн 2018 оны зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт Нээлттэй тендер шалгаруулалт 6, Харьцуулалтын аргаар 15 худалдан авалт, Шууд худалдан авалт 21 ширхэг тус бүр тусгагдсанаас 3-р улирлын байдлаар Нээлттэй тендер шалгаруулалт 2, Харьцуулалтын аргаар 5 худалдан авалт хийгдэж, Шууд худалдан авалт 9 удаа хийгдсэн болно.

Нийт харьцуулалтын аргаар болон нээлттэй тендер шалгаруулалтаар хийгдсэн худалдан авалтуудаас шалгарсан болон шалгараагүй оролцогч нарт хуулийн үндэслэлийг тусгасан албан бичгээр хариуг мэдэгдэж, www.shilendans.gov.mn, www.mtz.mn, www.tender.gov.mn, www.mrtd.gov.mn зэрэг цахим сайтууд, өдрийн сонин, өнөөдөр сонингуудад худалдан авах ажиллагааны холбогдох мэдээллийг тогтмол байршуулан ил тод байдлыг ханган, шилэн данс, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах тухай хуулийн хүрээнд холбогдох худалдан авалтын тайлангуудыг бүрэн байршуулан ажиллаж байна. 2018 оны 3-р улирлын байдлаар худалдан авалтуудын талаар холбогдох санал гомдол оролцогч нараас ирүүлээгүй болно.

2018 оны төлөвлөгөөт худалдан авалтын үйл ажиллагааг үр дүнтэй, хэмнэлттэй, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн заалтыг чанд сахин, мөрдлөг болгон ажиллаж байна.